

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Яруу сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/153/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2022 он</p>	<p>Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Дагвасүрэн Утас: 99014227 Цахим хаяг: daqvasurend@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Баасанжаргал Утас: 99032514 Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn</p>
------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.2.1 Залруулсан алдаа	12
4.2.2 Төлбөрийн акт	12
4.2.3 Албан шаардлага	12
4.2.4 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЯРУУ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.ЛОСОЛМАА-д

2022.02.24 № 1302/256
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Яруу сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Яруу сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013025010

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	59,306,444.64	57,509,533.53
33	АВЛАГА	22,423.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	22,423.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59,284,021.64	57,509,533.53
351	Түүхий эд материал	1,596,250.00	2,023,840.00
35130	Эм боох материал	1,596,250.00	2,023,840.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	45,600.00	2,666,700.00
354	Хангамжийн материал	57,642,171.64	52,818,993.53
35410	Бичиг хэргийн материал	1,862,249.80	2,905,449.80
35420	Аж ахуйн материал	42,155,150.84	40,599,161.73
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	153,966.00
35440	Түлш, шатах тослох материал	2,454,750.00	1,600,000.00
35450	Барилгын засварын материал	1,205,800.00	1,357,000.00
35460	Хүнсний материал	8,030,229.00	4,269,424.00
35470	Бусад хангамжийн материал	1,933,992.00	1,933,992.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	343,201,358.85	347,484,973.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	343,201,358.85	347,484,973.73
392	Биет хөрөнгө	336,753,983.85	341,450,098.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	354,067,637.00	354,067,637.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-25,290,545.52	-37,935,818.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,558,202.00	43,539,102.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,522,097.83	-23,549,347.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,944,313.56	26,900,409.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,592,826.04	-23,854,518.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,362,757.50	8,362,757.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,241,646.82	-6,548,313.54
39217	Ном	468,190.00	468,190.00
393	Биет бус хөрөнгө	6,447,375.00	6,034,875.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-240,625.00	-653,125.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,038,000.00	5,038,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	402,507,803.49	404,994,507.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,477,356.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,477,356.00
413	Өглөг	00.00	1,477,356.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,477,356.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	402,507,803.49	403,517,151.26
51	Засгийн газрын хувь оролцоо	402,507,803.49	403,517,151.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	418,508,960.38	418,508,960.38
51101	Өмч: - төрийн	418,508,960.38	418,508,960.38
512	Хуримтлагдсан үр дүн	-80,614,847.33	-79,605,499.56
51210	Өмнөх үеийн үр дүн	-80,614,847.33	-80,614,847.33
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	1,009,347.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,613,690.44	64,613,690.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	402,507,803.49	404,994,507.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	232,813,200.00	251,148,584.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,499,000.00	9,569,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,499,000.00	9,569,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,499,000.00	9,569,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,499,000.00	9,569,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,314,200.00	241,579,084.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	217,040,200.00	229,305,084.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	217,040,200.00	229,305,084.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,274,000.00	12,274,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,274,000.00	12,274,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	236,411,290.58	250,139,236.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	236,411,290.58	250,139,236.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	220,496,923.58	232,565,192.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,892,006.00	166,096,723.00
210101	Үндсэн цалин	111,141,848.00	102,180,499.00
210102	Нэмэгдэл	32,756,591.00	46,426,986.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	468,750.00	3,750,000.00
210104	Урамшуулал	12,524,817.00	13,739,238.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,658,304.00	21,456,576.00
210201	Тэтгэврийн даатгал	12,178,704.00	14,581,110.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,619,900.00	1,660,967.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,295,900.00	1,328,773.00
210204	Ажилгүйдлийн даатгал	324,000.00	332,193.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,239,800.00	3,553,533.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,053,769.00	12,415,084.00
210301	Гэрэл, цахилгаан	1,186,519.00	1,160,334.00
210302	Түлш, халаалт	12,427,250.00	10,354,750.00
210303	Цэвэр, бохир ус	440,000.00	900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,307,080.00	7,495,189.11
210401	Бичиг хэрэг	596,550.00	811,400.00
210402	Тээвэр, шатахуун	119,500.00	822,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,007,800.00	752,700.00
210404	Ном, хэвлэл	00.00	45,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	583,230.00	824,482.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,239,107.11
2105	Нормативт зардал	11,589,261.00	8,133,535.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	459,600.00	1,108,510.00
210502	Хоол, хунс	11,079,661.00	7,025,025.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000.00	408,500.00
210604	Урсгал засвар	4,000.00	408,500.00
2107	Томилолт, зочны зардал	681,900.00	515,400.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	681,900.00	515,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	350,000.00	540,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	540,000.00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,960,603.58	15,504,185.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,091,550.00	662,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	14,869,053.58	14,842,185.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,914,367.00	17,574,044.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	8,815,584.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,607,084.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	208,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,914,367.00	8,758,460.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,914,367.00	8,758,460.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-3,598,090.58	1,009,347.77
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-3,598,090.58	1,009,347.77

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	418,508,960.38	64,613,690.44	-80,614,847.33	00.00	402,507,803.49
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	418,508,960.38	64,613,690.44	-80,614,847.33	00.00	402,507,803.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	418,508,960.38	64,613,690.44	-80,614,847.33	00.00	402,507,803.49
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,009,347.77	00.00	1,009,347.77
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	418,508,960.38	64,613,690.44	-79,605,499.56	00.00	403,517,151.26

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	229,314,200.00	241,579,084.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,314,200.00	241,579,084.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	217,040,200.00	229,305,084.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	217,040,200.00	229,305,084.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,274,000.00	12,274,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,274,000.00	12,274,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	227,054,200.00	231,531,284.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	227,054,200.00	231,531,284.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	211,139,833.00	213,957,240.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,914,429.00	166,074,300.00
210101	Үндсэн цалин	111,141,848.00	102,158,076.00
210102	Нэмэгдэл	32,779,014.00	46,426,986.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	468,750.00	3,750,000.00
210104	Урамшуулал	12,524,817.00	13,739,238.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,658,304.00	19,979,220.00
210201	Тэтгэврийн даатгал	12,178,704.00	13,103,754.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,619,900.00	1,660,967.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,295,900.00	1,328,773.00
210204	Ажилтуйдлийн даатгал	324,000.00	332,193.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,239,800.00	3,553,533.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,554,300.00	11,714,300.00
210301	Гэрэл цахилгаан	1,314,300.00	1,314,300.00
210302	Түлш, калаалт	9,500,000.00	9,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	740,000.00	900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,119,300.00	5,008,100.00
210401	Бичиг хэрэг	606,200.00	762,400.00
210402	Тээвэр, шатахуун	822,000.00	822,000.00
210403	Шүүдэн холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	752,700.00
210404	Ном, хэвлэл	45,600.00	45,500.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх, ажуйн эд зүйлс	2,845,500.00	2,625,500.00
2105	Нормативт зардал	15,389,600.00	7,421,420.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,036,100.00	1,536,100.00
210502	Хоол хүнс	12,036,400.00	3,264,220.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,317,100.00	2,621,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	559,700.00	559,700.00
210604	Урсгал засвар	559,700.00	559,700.00
2107	Томилголт, зочны зардал	681,900.00	515,400.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	681,900.00	515,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00	540,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	540,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	150,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,762,300.00	2,144,800.00
210902	Хинээд үйлдвэрлэлийн даллага хийж	1,762,300.00	2,144,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,914,367.00	17,574,044.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	8,815,584.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,607,084.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	208,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,914,367.00	8,758,460.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,914,367.00	8,758,460.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,260,000.00	10,047,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЫН ДҮН (5)	2,260,000.00	10,047,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,260,000.00	10,047,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,260,000.00	10,047,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,260,000.00	10,047,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,260,000.00	-10,047,800.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	232,472,000.00	223,713,540.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	232,472,000.00	223,713,540.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	232,263,500.00	223,505,040.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,790,700.00	166,074,300.00
210101	Үндсэн цалин	113,093,300.00	102,158,076.00
210102	Нэмэгдэл	37,146,400.00	46,426,986.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	500,000.00	3,750,000.00
210104	Урамшуулал	12,051,000.00	13,739,238.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,307,600.00	19,979,220.00
210201	Тэтгэврийн даатгал	14,796,000.00	13,103,754.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,627,900.00	1,660,967.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,302,300.00	1,328,773.00
210204	Ажилгүйдлийн даатгал	325,600.00	332,193.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,255,800.00	3,553,533.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,714,300.00	11,714,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,314,300.00	1,314,300.00
210302	Түлш, халаалт	9,500,000.00	9,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,228,100.00	5,728,100.00
210401	Бичиг хэрэг	762,400.00	762,400.00
210402	Тээвэр, шатахуун	822,000.00	822,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	752,700.00	752,700.00
210404	Ном, хэвлэл	45,500.00	45,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,845,500.00	3,345,500.00
2105	Нормативт зардал	26,359,700.00	7,421,420.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,536,100.00	1,536,100.00
210502	Хоол, хүнс	22,869,000.00	3,264,220.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,954,600.00	2,621,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	559,700.00	559,700.00
210604	Урсгал засвар	559,700.00	559,700.00
2107	Томилолт, зочны зардал	681,900.00	515,400.00
210702	Дотоод албан томилолт	681,900.00	515,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	409,200.00	540,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	409,200.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	221,230.00	1,097,260.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,212,300.00	10,972,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	208,500.00	208,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	208,500.00	208,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	208,500.00	208,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	232,472,000.00	232,472,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	220,198,000.00	220,198,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	220,198,000.00	220,198,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,274,000.00	12,274,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	12,274,000.00	12,274,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15.00	15.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9,107,084.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9,107,084.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,607,084.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,607,084.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		8,607,084.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Яруу сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Яруу сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Яруу сумын Хүүхдийн цэцэрлэгийн сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар товч тодорхойллоо. Үүнд:

Багш ажилтны ажлын хариуцлага, ёс зүй, эерэг хандлагыг эрхэмлэн шударга хүртээмжтэй боловсролын үйлчилгээг үзүүлж, хүүхэд бүрийг уламжлалт ёс заншилаа дээдлэн хүндэлдэг, сурч мэдэх хүсэл эрмэлзэлтэй, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй иргэн болгон төлөвшүүлэх суурийг тавьж, эрүүл аюулгүй орчинд асран хүмүүжүүлэх зорилгын хүрээнд 3 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Яруу сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 251,148.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,767.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,825.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	22.40	-	(22.40)
Бараа материал	59,284.00	57,509.50	(1,774.50)
Үндсэн хөрөнгө	343,201.40	347,485.00	4,283.60
Нийт хөрөнгө	402,507.80	404,994.50	2,486.70
Өр төлбөр	-	1,477.40	1,477.40
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	402,507.80	403,517.10	1,009.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	402,507.80	404,994.50	2,486.70

Авлага дансны үлдэгдэл 22.4 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлагыг тайлант онд барагдсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 1,774.5 мянган төгрөгөөр буурсан нь материалын худалдан авалт бага байсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,283.6 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,477.4 мянган төгрөг болж өссөн нь ажиллагсадтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,009.3 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 241,579.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 241,579.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 229,305.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 12,274.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 231,531.2 мянган төгрөгийг зарцуулж, 8,758.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гүйцэтгэлээр дээд шатны төсөв захирагчаас 9,107.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, хангамж бараа материалын зардалд 500.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 8,607.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн, Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цагалбар, болон НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу бэлтгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төсвийн тухай хууль болон НББ-ийн тухай хууль бусад заавар журмыг дагаж мөрдсөн байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүүхдийн хоолны нормыг тогтоосон хэмжээнд олгосон эсэхийг шалгах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,466.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,854.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, , 8,612.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулгын алдаа гараагүй болно.

4.2.2 Төлбөрийн акт

Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас багш, ажилчдад биеийн тамирын хувцас 1,854.6 мянган төгрөгөөр худалдан авч олгосон алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.2.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Төсвийн аривлан хэмнэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2020 онд нийлүүлэгдсэн “Си-Ту-Эс” ХХК-аас 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг одоог хүртэл ашиглаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 17-той нийцэхгүй бөгөөд тохиолдсон байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

“Си-Ту-Эс” ХХК-аас худалдан авсан 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн програмыг 2022 оны 03 дугаар сарын 01-ээс ашиглаж эхлэх.

2 НББ, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шатахууныг орлогод аваагүй, шууд зардлаар тайлагнасан 822.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэсэн заалт, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаал болон санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын заавар журмыг мөрдөн ажиллах зөвлөмж өгсөн.

3 НББ, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Харилцагч байгууллага болон иргэнд төлсөн төлбөрийн баримтгүй /и-баримт/ ажил гүйлгээ гаргасан 6,140.0 мянган төгрөг байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудтай нийцэхгүй бөгөөд иж бүрэн байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ”; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян.төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		4	10,466.6			1	1,854.6			3	8,612.0
	Дүн	4	10,466.6			1	1,854.6			3	8,612.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Дүн										
	Нийт дүн										

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА 2022.02.25

АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН 2022.02.25

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Г.БААСАНЖАРГАЛ 2022.02.25